ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 11 сарын 29 өдөр Дугаар 09/85 Чойр

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, Нийцлийн аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн Нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгөөр Сумын төвийг камержуулах 15,000.0 мянган төгрөгийн ажлыг "Чойрын долгион" ХХК-тай гэрээг байгуулж гүйцэтгүүлсэн боловч камерын суурилуулалт хангалтгүйгээс салхитай өдөр камер ажилладаггүй, 2 камер нь ажиллагаагүй болсон
- 3 дугаар цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажлыг "Альянстрейд" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч 4 ширэмтэй пийшингийн тень шатснаас 2 ширэм нь ажиллагаагүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасан алдаа, зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн чанаргүй болон эвдэрсэн ажлуудыг гүйцэтгэгч байгууллагуудаар дахин засварлуулж, ашиглалтанд оруулж, зориулалтын дагуу бүрэн ашиглах

280319

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 05 дугаар сарын 15-ны дотор гаргаж, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Шивээговь сумын Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цэвээндулам, Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн З.Баасандалай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН[1]:

АХЛАХ АУДИТОР
Ц.БАТСАЙХАН

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
Г.НАРАНБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:
Ж.ЦЭВЭЭНДУЛАМ

НИЙГМИЙН БОДЛОГО, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
З.БААСАНДАЛАЙ

---

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*